



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 27

#### **ЗАСГИЙН ГАЗРЫН КОМИСС, ХОРОО, ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ, АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 6.1, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 20.3, Цөмийн энергийн тухай хуулийн 10.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.6, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.3, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.2, Усны тухай хуулийн 9.1.5, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41.2, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 8.3, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.2, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.4, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 132.3, Хүнсний тухай хуулийн 18.4, Монгол Улсын хилийн тухай хуулийн 29.1-д заасныг болон Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2014 оны 17 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: /Энэ хэсэгт ЗГ-ын 2017 оны 93-р тогтоолоор нэмэлт орсон/

1. Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Стандартчиллын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 5 дугаар, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 6 дугаар, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг 7 дугаар, Хэмжил зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 8 дугаар, Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 9 дүгээр, Усны үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 10 дугаар, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 11 дүгээр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг 12 дугаар, Хөдөө аж ахуйн гаралтай бараа,

түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 13 дугаар, Тогтвортой хөгжлийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 14 дүгээр, Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 15 дугаар, Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 16 дугаар, Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 17 дугаар, Монгол судлалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 18 дугаар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 19 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай. /Энэ заалтад ЗГ-ын 2017 оны 77-р тогтоолоор өөрчлөлт орсон/

2. Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсэг болон тэдгээрийн даргыг 20 дугаар хавсралт ёсоор баталсугай. /Энэ тогтоолын 5-р хавсралтад ЗГ-ын 2017 оны 77-р тогтоолоор өөрчлөлт орсон. Энэ тогтоолын 5-р хавсралтад ЗГ-ын 2017 оны 137-р тогтоолоор нэмэлт орсон. ЗГ-ын 2017 оны 93-р тогтоолоор 21-р хавсралт, 288-р тогтоолоор 22-р хавсралтыг нэмсэн/

3. Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах энэ тогтоолын 20 дугаар хавсралтаар баталсан орон тооны бус комисс, хороо, зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг холбогдох Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн, Засгийн газрын агентлагийн даргатай тохиролцсоны үндсэн дээр шинэчлэн баталж ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

4. Хууль тогтоомжид заасан байнгын үйл ажиллагаатай, орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсэг байгуулахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

5. Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий зөвлөл, комисс, хороо, ажлын хэсгийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахалж, бүрэлдэхүүнийг томилон ажиллаж тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг Засгийн газарт танилцуулж байхаар тогтоосугай.

6. Засгийн газраас баталсан салбар дундын чанартай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий зөвлөл, комисс, хороо, ажлын хэсгийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүд тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын аль нэг гишүүн ахалж, бүрэлдэхүүнийг томилон ажиллаж хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг Засгийн газарт танилцуулж байхаар тогтоосугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2005 оны 44 дүгээр тогтоолоор баталсан ““Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр”-ийн Тавдугаар хэсгийн 1 дүгээр зүйлийн “б” заалтын “... Монгол Улсын Ерөнхий сайд...” гэснийг “...байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ...” гэж, мөн хэсгийн 1 дүгээр зүйлийн “г” заалтын “...Байгаль орчны сайд...” гэснийг “...байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга...” гэж, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр

сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор баталсан ““Дэлхийн монголчууд” хөтөлбөр”-ийн 7.2 дахь заалтын “...Засгийн газар...” гэснийг “гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн...” гэж, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан ““Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн 6.2 дахь заалтын “...Засгийн газар...” гэснийг “гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн...” гэж, Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 287 дугаар тогтоолоор баталсан ““Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр”-ийн 5.2 дахь заалтын “...Засгийн газар...” гэснийг “...хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн...” гэж тус тус өөрчилсүгэй.

8. Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 88 дугаар тогтоолоор баталсан “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүн”-нд дор дурдсан агуулга бүхий 39 дүгээр заалт нэмсүгэй:

“39. Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан комиссын Монголын хэсэг

Дарга-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Архивын ерөнхий газрын дарга Орлогч дарга-Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын захирал”

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоол, “Хүн амын асуудлаархи үндэсний хороо байгуулах тухай” Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 97 дугаар тогтоол, “Гаалийн тарифын зөвлөлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 97 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 392 дугаар тогтоол, “Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 35 дугаар тогтоол, “Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 69 дүгээр тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 206 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 268 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 401 дүгээр тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 409 дүгээр тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 428 дугаар тогтоол, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 473 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 475 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 56 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 236 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016

оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 1 дүгээр тогтоол, “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 70 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 89 дүгээр тогтоол, “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 168 дугаар тогтоол, “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 179 дүгээр тогтоол, “Хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 192 дугаар тогтоол, “Нээлттэй засгийн түншлэлийн тухай” Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 381 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл, “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 245 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан 2012 оны 98 дугаар тогтоолын 20 дугаар хавсралт, “Дүрэм баталж, тогтоолд нэмэлт оруулах тухай” Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 143 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, “Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай” Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 136 дугаар тогтоолоор баталсан 1 дүгээр хавсралт, “Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 501 дүгээр тогтоолын 13 дугаар зүйл, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 195 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Ж.МӨНХБАТ

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ  
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга	-Монгол Улсын Ерөнхий сайд
Дэд дарга	- Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
Гишүүд:	<ul style="list-style-type: none"><li>-Хүний эрхийн үндэсний комиссын дарга (зөвшилцсөнөөр);</li><li>-Үндэсний статистикийн хорооны дарга (зөвшилцсөнөөр);</li><li>-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;</li><li>-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;</li><li>-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга;</li><li>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга;</li><li>-Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга;</li><li>-Хараагүйчүүдийн хөдөлмөр, сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал;</li><li>-Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);</li><li>-Хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);</li><li>-Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);</li></ul>

-Монгол Улсын сонсголгүй иргэдийн үндэсний холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төвийн захирал (тохиролцсоноор);

-Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүн (тохиролцсоноор);

-“Түгээмэл хөгжил” төвийн тэргүүн (тохиролцсоноор);

-“Тэгш нийгэм холбоо” төрийн бус байгууллагын тэргүүн (тохиролцсоноор).

Нарийн бичгийн  
дарга

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан нэгжийн дарга